

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванхоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн” мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ” 7 дахь хэсэгт төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана гэж тус тус заасан. Иймээс ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох нь Үндсэн хуулийн үзэл санаатай нийцнэ.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд Төрийн далбааг байнга болон түр хугацаагаар мандуулах газрыг, энэ хуулийн хуулийн 25 дугаар зүйлд Иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллагын төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх чөлөөг тус тус тогтоосон. Хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад бүх шатны боловсролын байгууллагын хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаа эхлэхэд Төрийн дууллыг эгшиглүүлэхийг зохицуулсан боловч ерөнхий боловсролын сургуулийн орчинд төрийн далбааг өдөр тутмын хичээл, сургалтын үйл ажиллагаатай уялдуулан хэрэглэх асуудлыг тусгайлан тодорхойлоогүй байна.

Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт “монголын түүх, монгол хэл уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил;”-ийг тусгаж хэрэгжүүлэхээр хуульчилсан. Боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт нь суралцагчийг ёс зүйтэй, хариуцлагатай эх оронч иргэн болгон төлөвшүүлэх зорилготой тул сургуулийн орчинд төрийн далбааг хүндэтгэлтэй хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхой болгох нь боловсролын салбарын бодлого, агуулгатай шууд уялдана.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна” гэх зорилтыг дэвшүүлсэн. Иймд ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн хугацаанд төрийн далбааг хүндэтгэлтэй мандуулах эрх зүйн үндсэн бий болгох нь уг бодлоготой нийцнэ.

Хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

1.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид ерөнхий боловсролын сургуулийг төрийн далбааг түр хугацаагаар мандуулах газрын хүрээнд тусгайлан нэрлээгүй тул сургуулиудын хэрэгжилт харилцан адилгүй байна.

2. Төрийн далбааг сургуулийн орчинд, хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд хүндэтгэлтэй хэрэглэх нь суралцагчдад төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх ухамсар, эх оронч үзэл, иргэний хариуцлагыг төлөвшүүлэх бодит хэрэгсэл болно.

3.Сургуулийн орчин нь хүүхэд, залуучуудад нийтлэг үнэт зүйл, үндэсний бахархал, нийтийн дэг журам, хүндэтгэлийн соёлыг төлөвшүүлэх хамгийн өргөн хамрах хүрээтэй институцийн орчин учраас төрийн далбаатай холбоотой эрх зүйн үндсийг энэ түвшинд тодорхой болгох шаардлагатай.

4.Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс хийсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд улс орон сургуулийн орчинд төрийн далбааг хэрэглэх асуудлыг боловсролын байгууллагын онцлогтой уялдуулан зохицуулсан бөгөөд Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой дунд түвшний, хэт албадлагатай бус загварууд байна.

Хуулийн төсөлд тусгасан гол зохицуулалт

Хуулийн төсөлд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад **“Ерөнхий боловсролын сургуульд хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд Төрийн далбааг мандуулна”** гэж нэмэхээр тусгасан.

Энэхүү зохицуулалтын үр дүнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ерөнхий боловсролын сургуулиуд төрийн далбааг түр хугацаанд мандуулах эрх зүйн тодорхой суурьтай болно.

Хуулийн төсөл нь төрийн далбааг түр хугацаанд мандуулах газрын хүрээг тодорхой болгох суурь зохицуулалтыг хуульд тусгаж байгаа бөгөөд хэрэгжилтийн нарийвчилсан асуудлыг холбогдох журам, протокол, аргачлалаар тодорхойлох боломжийг нээлттэй үлдээсэн. Ингэснээр хуулийн түвшинд хэт нарийвчилсан, хэрэгжилтийг хүндрүүлэх зохицуулалт бий болгохгүйгээр сургуулийн орчинд хичээлийн жилийн хугацаанд төрийн бэлгэ тэмдгийг хүндэтгэлтэй хэрэглэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

Олон улсын харьцуулсан зохицуулалт, Монгол Улсад хэрэгжүүлж болох загвар

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн “Бүх шатны сургуулиудад төрийн далбааг хэрэглэж буй бусад улсын туршлага” судалгаанаас үзэхэд бусад улс орнууд сургуулийн орчинд төрийн далбааг хэрэглэх асуудлыг гурван үндсэн загвараар зохицуулж байна. Монгол Улсын нөхцөлд эдгээрээс хэт албадлагатай бус, хэрэгжүүлэхэд бодитой, боловсролын зорилготой уялдсан загвар илүү тохиромжтой гэж үзэж байна.

Улсын загвар	Гол зохицуулалт	Монгол Улсад хэрэгжүүлэх боломж
Франц	Сургуулийн фасад болон анги танхимд төрийн далбааг байнга байршуулж, өдөр тутам харагдах орчныг бүрдүүлдэг боловч өдөр бүр ёслол үйлдэхийг албаддаггүй.	Монгол Улсад хамгийн нийцтэй суурь загвар. Хуулиар сургуульд төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн үндсийг тогтоож, өдөр тутмын хэт хатуу ёслолын шаардлага тавихгүй хэрэгжүүлэх боломжтой.
Австрали (Виктория)	Төрийн далбааг сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглахыг зөвшөөрч, хэрэгжилтийг протокол, удирдамж, сургуулийн зохион байгуулалттай уялдуулдаг.	Хуульд ерөнхий үндсийг тогтоогоод, хэрэгжилтийн нарийвчилсан журмыг боловсролын асуудал эрхэлсэн байгууллагын хамтарсан удирдамжаар зохицуулахад тохиромжтой.
Сингапур	Сургуулийн орчинд төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэхийг иргэний болон үндэсний боловсролын агуулгатай уялдуулж ирсэн. Хатуу хуульчилснаас илүү боловсролын хөтөлбөрөөр дамжуулан хэвшүүлдэг.	Хуулийн зорилгыг эх оронч үзэл, иргэний ухамсар төлөвшүүлэхтэй холбож, сургалтын агуулга, хүмүүжлийн үйл ажиллагаатай уялдуулахад тохиромжтой.
Филиппин	Долоо хоног бүрийн тогтмол ёслол, далбаа мандуулах ба буулгах ажиллагааг хуульчилж, боловсролын байгууллагад заавал мөрдүүлдэг.	Монгол Улсад тэмдэглэлт өдөр, хичээлийн жилийн нээлт, хаалт, улсын хэмжээний ёслолын үед хэрэглэх хөнгөн хувилбарыг дараагийн шатны журмаар тусгах боломжтой.

Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд Монгол Улсын хувьд Францын өдөр тутмын харагдах орчин бүрдүүлэх” загвар, Австралийн “удирдамжаар хэрэгжүүлэх” загвар, Сингапурын “иргэний боловсролтой уялдуулах” загварын хослол илүү оновчтой байна.

Харин Филиппиний долоо хоног бүрийн заавал ёслол үйлдэх загварыг бүхэлд нь хуулбарлахын оронд зөвхөн тэмдэглэлт болон сургуулийн онцгой тохиолдолд хэрэглэх зохицуулалтыг журмаар тусгах нь Монгол Улсын боловсролын байгууллагын хэрэгжилтийн бодит нөхцөлд илүү нийцнэ.

Монгол Улсад хэрэгжүүлэх санал болгож буй зохицуулалтын чиглэл

1.Хуулийн түвшинд ерөнхий боловсролын сургуульд хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд төрийн далбааг түр хугацаанд мандуулах суурь зохицуулалтыг тусгах;

2.Хэрэгжилтийн асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдамж, зөвлөмжтэй уялдуулах хэрэгжүүлэх;

3.Төрийн далбааг хэрэглэх асуудлыг хичээлийн жилийн нээлт, хаалт, үндэсний баяр, тэмдэглэлт өдөр болон сургуулийн хичээлийн жилийн хугацаанд боловсролын үйл ажиллагаатай уялдуулах;

4.Суралцагчдад төрийн далбааны утга, бэлгэдэл, зөв хэрэглэх соёлыг тайлбарласан агуулгыг сургалтын болон хүмүүжлийн үйл ажиллагаанд тусгах.

Хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар ерөнхий боловсролын сургуулиудад хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд төрийн далбааг түр хугацаагаар мандуулах эрх зүйн үндэс тодорхой болж улсын болон хувийн сургуулиудын хэрэгжилтийн ойлголт нэг мөр бүрдэнэ.

Сургуулийн орчинд төрийн далбааг хүндэтгэлтэй хэрэглэх нь суралцагчдын үндэсний бахархал, эх оронч үзэл, төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх ухамсрын төлөвшүүлэхэд ач холбогдолтой бөгөөд зөв хэрэглэх соёлыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Төсөл нь одоо байгаа сургуулийн тогтолцооны хүрээнд хэрэгжих боломжтой бөгөөд шинээр байгууллага байгуулах, нэмэлт бүтэц бий болгох шаардлагагүйгээр хэрэгжих давуу талтай.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

---оОо---